



ИНШҮРКО
ДААТГАЛ

КОМПАНИЙН ТАНИЛУУЛГА

ИНШҮРКО ДААТГАЛ ХХК

Эрсдэлгүйгээр урагшилъя



ГАНБЯМБА НАВААНСАМДАН

Үүсгэн байгуулагч | ТУЗ гишүүн

ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ

Иншүрко Даатгал ХХК-ийн эрхэм харилцагчид, хамтран ажиллагч байгууллагууд, эрхэм түншүүд Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Манай компани үйл ажиллагааныхаа туршид бизнесийн тогтвортой өсөлтийг хангах, санхүүгийн сахилга бат, эрсдэлийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлэх, харилцагчийн эрх ашиг, итгэлийг нэн тэргүүнд тавих бодлогыг тууштай баримтлан ажиллаж ирлээ.

Энэхүү зорилгын хүрээнд бид стратегийн зорилтоо хэрэгжүүлж, инновацлаг шийдлээр харилцагчдад урт хугацааны үнэ цэнийг бий болгоход анхаарч байна.

Бид компанийн засаглалыг бэхжүүлэх, ил тод, хариуцлагатай, үр ашигтай удирдлагын тогтолцоог төлөвшүүлэхийн зэрэгцээ дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, нийцлийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн тасралтгүй сайжруулж байна. Мөн дижитал шилжилтийг эрчимжүүлж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, харилцагч төвтэй, технологид суурилсан шийдлүүдийг үе шаттайгаар нэвтрүүлснээр компанийн дунд болон урт хугацааны өрсөлдөх чадварыг улам бэхжүүлэхийг зорин ажиллаж байна.

Эдгээр амжилт, ахиц дэвшил нь бидний хамтын хүчин чармайлт, итгэлцэл, тууштай ажиллагааны үр дүн бөгөөд манай харилцагчид, түнш байгууллагууд, хамтран ажиллагчид болон нийт ажилтнуудын бодит оролцоо, дэмжлэггүйгээр боломжгүй билээ. Иймд Та бүхэндээ гүн талархал илэрхийлье.

Цаашид Иншүрко Даатгал ХХК нь харилцагчийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжил, хариуцлагатай засаглалыг эрхэмлэсэн бодлогоо тууштай хэрэгжүүлж, даатгалын салбартаа итгэл даасан, найдвартай байгууллага байх зорилтоо улам бататган ажиллах болно. Бид харилцагч, түншүүдтэйгээ урт хугацаанд хамтран хөгжих, үнэ цэнийг хамтдаа бүтээхийг эрхэмлэн, илүү хүртээмжтэй, чанартай, найдвартай үйлчилгээг хүргэхэд анхаарах болно.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж, ажил үйлсэд тань өндөр амжилт хүсье.



ТОМОХИКО УЭМУРА

ТУЗ Дарга | Хувьцаа эзэмшигч

ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН ТӨЛӨӨЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм харилцагчид, түншүүд Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Намайг “Иншүрко Даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Томохиико Уэмүра гэдэг.

Өргөн уудам боломж, залуу эрч хүч, арвин байгалийн нөөцөөрөө онцлог Монгол Улс нь эдийн засгийн өсөлт, ирээдүйг чиглэсэн бодлогын дэмжлэгтэйгээр хөгжлийн шинэ шатанд шилжиж байна.

Ийм чухал цаг үед “Иншүрко Даатгал” ХХК нь Монголын анхны гадаадын хөрөнгө оруулалттай ердийн даатгалын компани болохын хувьд Япон, Монголын соёл, бизнесийн гүүр болж, хувь хүн болон байгууллагуудыг итгэлтэй, тайван хөгжихөд дэмжин ажиллаж байна.

Манай эрхэм зорилго бол дэвшилтэт технологид суурилж, олон улсын стандартад нийцсэн чанартай даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан Монголын иргэд, аж ахуйн нэгжүүдэд бодит хамгаалалт, санхүүгийн тогтвортой байдал, сэтгэлийн амар тайвныг хүргэхэд оршино. Бид даатгалыг зөвхөн хохирол нөхөн төлөх хэрэгсэл бус, харин ирээдүйд итгэх итгэл, тогтвортой өсөлтийн суурь гэж үздэг.

Итгэлцэл бол бидний үйл ажиллагааны гол тулгуур бөгөөд хамгийн эрхэм үнэт зүйл юм. Бид харилцагч бүрийн хэрэгцээ, зорилго, ирээдүйн төлөвийг ойлгож, урт хугацаанд хамтран ажиллах найдвартай түнш нь байхыг зорьдог. Үүний зэрэгцээ Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж, даатгалын салбарт шинэ соёл, өндөр стандартыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Бидний зорилго зөвхөн өнөөдрийг хамгаалахад бус, харин түншүүд, оролцогч талуудтайгаа хамтран илүү аюулгүй, илүү тогтвортой, илүү итгэлтэй ирээдүйг бүтээхэд чиглэж байна.

Иймд даатгалын салбарын шинэ үеийг хамтдаа эхлүүлж, Монгол Улсын тогтвортой өсөлт, хөгжил, хамтын хөгжил цэцэглэлтийн дараагийн шатны бүтээлцэх үйлсэд Та бүхнийг нэгдэхийг урьж байна.



СОЛОНГО БЯМБАДОРЖ

Гүйцэтгэх захирал

ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм харилцагчид, хамтран ажиллагч байгууллагууд, эрхэм хувьцаа эзэмшигчид Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

“Иншүрко Даатгал” ХХК нь даатгалын салбарт олон улсын стандарт, дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэглэгч төвтэй бизнесийн соёлыг төлөвшүүлэх зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа тасралтгүй өргөжүүлэн ажиллаж байна.

Бид эрсдэлийн найдвартай удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, харилцагч бүрт түргэн шуурхай, ил тод, чанартай үйлчилгээг хүргэхэд онцгойлон анхаарч байна.

Компанийн гүйцэтгэх удирдлагын баг өдөр тутмын үйл ажиллагаандаа санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны үр ашиг, харилцагчийн сэтгэл ханамжийг нэн тэргүүнд тавьж, бизнесийн процессыг сайжруулах, хурд болон ил тод байдлыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллалаа. Мөн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлийг бодит хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлуудыг шат дараатай хэрэгжүүлж эхэллээ.

Бид дотоод нөөцдөө тулгуурлан хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, багийн уялдаа холбоог сайжруулах замаар хариуцлагатай, мэргэшсэн хамт олныг бүрдүүлэн компанийн үнэт зүйл, соёлыг бодит ажил хэрэг болгож, харилцагч бүрт чанартай, найдвартай үйлчилгээг хүргэх үндсэн хөдөлгөгч хүчин болгон ажиллаж байна.

Бид дижитал шийдлүүдийг үе шаттай нэвтрүүлж, дотоод процессуудыг автоматжуулан, мэдээллийн ил тод байдлыг сайжруулснаар харилцагчдад түргэн шуурхай, найдвартай үйлчилгээ үзүүлэх суурийг бүрдүүлж, компанийн үр ашиг болон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн. Цаашид “Иншүрко Даатгал” ХХК нь тогтвортой өсөлт, өндөр гүйцэтгэл, харилцагч төвтэй үйлчилгээний стандартыг хангаж, илүү уян хатан, шуурхай, найдвартай даатгалын үйлчилгээг хөгжүүлэн ажиллах болно. Бидэнд итгэл хүлээлгэн хамтран ажиллаж буй эрхэм харилцагчид, түнш байгууллагууддаа талархал илэрхийлье.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

УДИРДЛАГЫН БАГ



СОЛОНГО БЯМБАДОРЖ

Гүйцэтгэх захирал



УЯНГА ДАШЖАМЦ

Үйл ажиллагааны газрын захирал



ТУУЛ МЯГМАРДОРЖ

Андеррайтинг, Бизнес хөгжлийн газрын захирал



ЭРХЭМБЯАР ӨЛЗИЙБУЯН

Даатгалын газрын захирал



**ОТГОНДАВАА
ЯНТАЙДОРЖ**

Эрсдэл, нөхөн төлбөрийн газрын захирал



АНАР АЛТАЙ

Санхүү удирдлагын газрын захирал

Гүйцэтгэх удирдлагын баг нь даатгал, санхүү, эрсдэлийн удирдлага, хууль эрх зүй болон бизнесийн салбарт арвин туршлага, өндөр мэргэшилтэй мэргэжилтнүүдээс бүрддэг. Тус баг нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулахын зэрэгцээ стратегийн зорилтуудыг хэрэгжүүлж, тогтвортой өсөлтийг ханган, компанийн засаглалын өндөр стандартыг мөрдүүлэн ажилладаг.

Салбарын гүнзгий мэдлэг, туршлагад тулгуурлан хэрэглэгч төвтэй даатгалын шийдлийг хөгжүүлж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эрсдэлийн удирдлагыг сайжруулах, дижитал шилжилтийг хурдасгах, бүтээгдэхүүний инновацийг дэмжих болон зах зээлийн тэлэлтийг хангахад анхаардаг. Ингэхдээ мэргэжлийн ур чадвар, хариуцлага, ёс зүй, ил тод байдлыг эрхэмлэн, хувьцаа эзэмшигч, харилцагч, ажилтан болон бизнесийн түншүүдэд урт хугацааны тогтвортой үнэ цэнийг бий болгохыг зорьдог.

БИДНИЙ ТУХАЙ

“Иншүрко Даатгал” ХХК нь 2023 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр “Иншүрко” ХХК нэртэйгээр байгуулагдаж, 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ны 94 дүгээр тогтоолын дагуу ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авснаар даатгалын салбарт хууль, эрх зүйн бүрэн зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Анх 4 ажилтантайгаар үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өнөөдөр 20 гаруй чадварлаг мэргэжилтнээс бүрдсэн мэргэжлийн баг болон өргөжин хөгжиж, байгууллагын тогтвортой өсөлт, институцийн хөгжил бодитоор хангагдаж байна.

Одоогийн байдлаар “Иншүрко Даатгал” ХХК нь даатгалын салбартаа хамгийн өндөр дүрмийн сантай компаниудын нэг болж, санхүүгийн тогтвортой байдал болон урт хугацааны өсөлтийн бат бөх суурийг бүрдүүлээд байна.

Компанийн эрхэм зорилго нь харилцагчидтай итгэлцэлд суурилсан харилцаа тогтоож, олон улсын стандартад нийцсэн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэн, эрсдэлийн оновчтой удирдлагаар тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад оршино. Мөн бид дижитал шилжилт, үйл ажиллагааны үр ашиг, засаглал, дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэхэд анхаарч байна. Цаашид “Иншүрко Даатгал” ХХК нь салбарын тэргүүлэгч болж, харилцагч болон хувьцаа эзэмшигчдийн урт хугацааны итгэлтэй түнш байхыг зорьж ажиллана.



КОМПАНИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

- 2024.03.20** “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авлаа.
- 2024.09.14** “Даатгагчийн баталгааны зөвлөл”-д нэгдлээ.
- 2025.03.20** “Иншүрко Даатгал” ХХК нь 1 нас хүрлээ.
- 2025.03.25** “Албан журмын даатгагчдын холбоо”-ны гишүүн боллоо.
- 2025.07.09** Тогтвортой хөгжлийг дэмжсэн Ногоон багц даатгалыг салбартаа анхлан зах зээлд нэвтрүүлээ.
- 2025.10.05** БОНЗ(Байгаль орчин, нийгэм, засаглал) тайланг боловсруулан тайлагнаж, тогтвортой хөгжил, ил тод байдлын чиглэлд шинэ алхам хийлээ.
- 2026.02.14** 14 хэлбэрийн 48 төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлж, борлуулалтын үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлж байна.
- 2026.03.26** Даатгалын салбарт Японы хөрөнгө оруулалтыг “Иншүрко Даатгал” ХХК анх удаа нэвтрүүлээ.
- 2026.03.31** Харилцагчдын тоо 20,000-д хүрч, хэрэглэгчийн бааз тогтвортой өсөлттэйгөөр өргөжин тэлж, зах зээл дэх компанийн байр суурь улам бүр бэхэжсэн байна.
- 2026.04.09** “Иншүрко Даатгал” ХХК нь Реппер | Продюсер | Бизнес эрхлэгч BIG GEE-г компанийн Брэндийн элчээр албан ёсоор томиллоо.

ИТГЭЛЦЭЛ
ХАРИУЦЛАГА
ХАМГААЛАЛТ
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

ҮНЭТ ЗҮЙЛ



АЛСЫН ХАРАА

Даатгуулагчийн эрсдэлийг бууруулсан, олон улсын жишигт нийцсэн даатгалын цогц үйлчилгээ үзүүлж, баялаг бүтээгч хүн бүрийн хамгийн итгэлтэй, зорилтот сонголт байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхийн жишигт нийцсэн даатгалын цогц үйлчилгээ

ИТГЭЛЦЭЛ

Итгэлцэл нь харилцан ойлголцол, хүндлэл, шударга зарчимд тулгуурласан харилцаа юм. “Иншүржко Даатгал” ХХК нь харилцагч болон ажилтнуудын итгэлийг эрхэмлэн хамгаалж, түүнийг тууштай хадгалахыг үйл ажиллагааныхаа үндсэн үнэт зүйл болгон ажилладаг.

ХАРИУЦЛАГА

Хариуцлага нь ёс зүй болон шударга байдлын зарчимд тулгуурладаг. Манай компани хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, гэрээний үүргээ цаг хугацаанд нь, зохих ёсоор биелүүлэхийг тууштай эрхэмлэн ажилладаг.

ХАМГААЛАЛТ

Бид харилцагч болон ажилтнуудын нийгмийн аюулгүй байдал, хамгаалалтыг нэн тэргүүнд тавьж, болзошгүй эрсдэл, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэхэд анхаардаг. Нийгмийн хамгааллыг бид байгууллагын үндсэн үнэт зүйлсийн нэг болгон эрхэмлэн ажилладаг.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Итгэлцэл, хариуцлага болон хамгааллын зарчимд тулгуурлан бид харилцагчид, ажилтнууд, компани болон нийгэм, эдийн засгийн тогтвортой урт хугацааны хөгжлийн төлөө үе шаттайгаар тууштай ажиллаж байна.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

“Иншүрко Даатгал” ХХК нь Японы хөрөнгө оруулагчтай стратегийн түвшний хамтын ажиллагааг эхлүүлж, урт хугацааны өсөлт, зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж байна. Уг хөрөнгө оруулалт нь компанийн капиталын суурийг бэхжүүлэх, дижитал шилжилтийг хурдасгах, олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэхэд чиглэж байгаа юм.

Энэхүү хөрөнгө оруулалт нь компанийн санхүүгийн чадавхыг бэхжүүлэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, урт хугацааны өсөлтийг дэмжих чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн уг хөрөнгө оруулалт нь зөвхөн компанийн хэмжээнд бус, Монгол Улсын даатгалын салбарын хөгжилд бодит ахиц авчрах, салбарыг нэг шат ахиулах ач холбогдолтой гэж үзэж байна. Олон улсын хөрөнгө оруулалт татагдсанаар зах зээлд өрсөлдөөн, үйлчилгээний чанар, ил тод байдал нэмэгдэж, даатгалын салбарын хөгжилд шинэ шатанд гарах боломж бүрдэж байна.

Хөрөнгө оруулалтын үр дүнд даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний инноваци, төрөлжилт нэмэгдэх, эрсдэлийн удирдлагын чадавх бэхжих, санхүүгийн тогтвортой байдал сайжрах зэрэг эерэг өөрчлөлтүүд бий болно. Мөн олон улсын стандарт, шилдэг туршлагыг нэвтрүүлэх боломж өргөжин, салбарын засаглал, хяналтын тогтолцоо, үйлчилгээний үр ашиг шинэ түвшинд хүрэх нөхцөл бүрдэнэ.

Тус хамтын ажиллагааны хүрээнд даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын стандарт, шилдэг туршлагыг нэвтрүүлэх, дижитал технологид суурилсан шийдлүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр зорьж байна. Ингэснээр харилцагчид илүү найдвартай, ил тод, хүртээмжтэй даатгалын үйлчилгээг авах нөхцөл бүрдэх бөгөөд хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтрэх боломж нэмэгдэнэ.

Манай компани цаашид харилцагчдынхаа итгэлийг эрхэмлэн, хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлагыг чанд мөрдөж, ил тод, хариуцлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн зэрэгцээ даатгалын салбарын хөгжилд эерэг хувь нэмэр оруулах зорилт тавин ажиллах болно.

ОНЦЛОХ ҮР ДҮН

+20,000

Даатгуулагчдын нийт
тоо (Иргэд)

+100

Даатгуулагчдын нийт
тоо (Байгууллага)

101%

Нөөц сангийн өсөлт

No.2

Дүрмийн сангийн
хэмжээгээр салбартаа
тэргүүлэгч

288.1%

Өөрийн хөрөнгөөр
эрсдэл үүрэх чадвар

+30

Хамтын ажиллагаа

48

Даатгалын
бүтээгдэхүүний тоо

**НОГООН
ДААТГАЛ**

БОНЗ ТАЙЛАН (БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ)

Уур амьсгалын өөрчлөлт, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагавар, тогтвортой хөгжилд тулгарах эрсдэлүүд эрчимжихийн хэрээр тэдгээрийг үр дүнтэй шийдвэрлэх нь нэн чухал болохыг зохицуулагчид, хөрөнгө оруулагчид, олон нийт ухамсарлан хүлээн зөвшөөрч тогтвортой хөгжлийн талаарх бодлого, санаачилгууд хурдацтай хөгжиж байгаа билээ.

Тогтвортой байдлын тайлагнал нь дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудын агуу байгууллагын үйл ажиллагааны эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлж байх байгууллагын дадал болж байна.

Иншүрко даатгал ХХК нь 2025 онд байгууллагын үйл ажиллагааны эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөлөл буюу БОНЗ-ын тайланг Даатгалын бодлогын зөвлөлийн зөвлөмжийн дагуу заагдсан хугацаанд ил тод, анхны удаа амжилттай тайлагнан ажиллав.



2025 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ

Бид 2025 оны байдлаар нийт борлуулалтын орлого 3,235 тэрбум төгрөгт хүрч, тогтвортой өсөлттэй байснаар компанийн үйл ажиллагааны үр ашиг, зах зээл дэх байр суурь улам бүр бэхэжсэнийг харууллаа. Энэхүү өсөлтөд Хөрөнгийн болон Зээлийн даатгалын бүтээгдэхүүний тогтвортой эрэлт, амжилттай хэрэгжилт голлон нөлөөлж, компанийн бүтээгдэхүүний багц зах зээлийн хэрэгцээнд илүү оновчтой нийцэж байгааг илтгэж байна.



1Q2025

₮ 884.3 сая
Хураамж

₮ 5.4 сая
Нөхөн төлбөр

0.6%

Хохирлын харьцаа

НИЙТ ХУРААМЖ &
НИЙТ НӨХӨН
ТӨЛБӨР

1Q2026

₮ 1,430.4 сая
Хураамж

₮ 165.9 сая
Нөхөн төлбөр

11.6%

Хохирлын харьцаа

НИЙТ ХУРААМЖ &
НИЙТ НӨХӨН
ТӨЛБӨР

БАТАЛГААНЫ ДААТГАЛ

Иншүрко Даатгал ХХК нь Иргэний хуулийн 457 дугаар зүйл, Даатгалын тухай хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 46 дугаар тогтоолоор нэмж баталсан "Даатгалын багц дүрэм"-ийн арван долоо дугаар хавсралт "ДААТГАГЧИЙН БАТАЛГАА ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ"-г тус тус үндэслэн "Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем"-д зарлагдаж буй бүх төрлийн тендерт тендерийн баталгаа болон холбогдох бусад баталгааг амжилттай гаргасан байна.

Нийт 7.26 тэрбум төгрөгний Баталгаа гаргаснаас:

Тендерийн баталгаа

₮ 1.15 тэрбум

Гүйцэтгэлийн баталгаа

₮ 3.35 тэрбум

Урьдчилгаа төлбөрийн баталгаа

₮ 2.76 тэрбум

ДАВХАР ДААТГАЛ

Бид тайлант онд “Үндэсний Давхар Даатгал” ХК-тай Трити гэрээ байгуулан үндсэн даатгалын багц бүтээгдэхүүнүүдийн эрсдэлийг хуваарилан хамтран ажиллаж байна.

Мөн Трити гэрээнээс гадна даатгалын үнэлгээ өндөр, хүлээгдэж буй хохирлын хэмжээ харьцангуй их байж болох даатгалын тохиолдолд тусгай нөхцөлтэй факултатив (нэг бүрчилсэн) давхар даатгалын хэлбэрээр олон улсын давхар даатгагч байгууллагуудтай хамтран ажиллалаа.

Эдгээр олон улсын давхар даатгагч байгууллагыг сонгохдоо манай компани дараах санхүүгийн болон зохицуулалтын шаардлагыг хангасан байх зарчмыг баримталж ажилладаг. Үүнд:

- ▼ Давхар даатгалын бодлогын хүрээнд эрсдэлийг шилжүүлж буй давхар даатгагчийн санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадварын үнэлгээнд тогтмол хяналт тавих, эрсдэлийн үнэлгээг судалгаа, тооцоололд үндэслэн хийдэг байх;
- ▼ Давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос тухайн чиглэлээр авсан байх;
- ▼ Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний агентлагуудаас доорх доод түвшний зэрэглэлээс дээш үнэлгээтэй байх, ба үүнд:
 - ▼ A.M. Best агентлагийн үнэлгээ: “А” түвшин ба түүнээс дээш;
 - ▼ Standard & Poor’s (S&P) болон Fitch Group: “BBB” түвшин ба түүнээс дээш;
 - ▼ Moody’s Corporation: “Baa” түвшин ба түүнээс дээш;
 - ▼ Rating Agency Expert RA: “А” түвшин ба түүнээс дээш зэрэглэлийн үнэлгээтэй байх.



FitchRatings



Mongolian Re

SINGAPORE RE

SmartChoice



БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖИЛ

Өнгөрсөн хугацаанд бид даатгалын бүтээгдэхүүний хэлбэр, төрлийг идэвхтэй өргөжүүлж, шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд илүү хурдтай нэвтрүүлэхэд анхааран ажилласан.

Энэ хүрээнд “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ноос 14 хэлбэрт хамаарах нийт 48 даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгох албан ёсны зөвшөөрөл авч, компанийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн стратегийг бодит хэрэгжилт болгон хэрэгжүүлэх боломжийг бүрдүүллээ. Мөн энэхүү үйл явдал нь холбогдох хууль, эрх зүйн шаардлагад бүрэн нийцсэн, системтэй бөгөөд тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлсэн чухал алхам болсон юм.

Ингэснээр харилцагч төвтэй, зах зээлийн хэрэгцээнд нийцсэн шинэлэг бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх бидний зорилт илүү бодит үр дүнд хүрэх нөхцөл бүрдэж байна.



НОГООН ДААТГАЛ

Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал нь хүн төрөлхтний өмнө тулгамдсан томоохон сорилт болж, байгаль орчны доройтол, цаг уурын гамшигт үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдсээр байна. Монгол Улсын хувьд энэхүү нөлөөлөл илүү мэдрэгдэж, экосистемийн тэнцвэр алдагдах, эдийн засагт сөрөг үр дагавар үүсэх нөхцөл бүрдэж байна.

Ийм нөхцөлд байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, тогтвортой хэрэглээг дэмжсэн ногоон хөгжлийн шийдлүүд нь зөвхөн байгаль орчны төдийгүй эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой болж байна. Үүнтэй уялдан даатгалын салбар ч мөн шинэчлэгдэж, байгаль орчны эрсдэлийг бууруулахад чиглэсэн ногоон даатгалын бүтээгдэхүүнүүд хөгжиж байна.

Бид тогтвортой хөгжлийн бодлого Монгол Улсын “Алсын хараа 2050”, Монгол Улсын Ногоон Таксономи (ТоС Холбоо) болон олон улсын чиг хандлагатай уялдуулан дараах 3 төрлийн ногоон даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэв.

НОГООН ЦАХИЛГААН БАРААНЫ ДААТГАЛ
НОГООН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ДААТГАЛ
НОГООН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛ



БРЕНДИЙН ЭЛЧ

“Иншүрко Даатгал” ХХК нь брэндийн үнэ цэнийг бэхжүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх стратегийн хүрээнд Реппер, продюсер, бизнес эрхлэгч BIG GEE-г албан ёсоор Брэндийн элчээр томиллоо.

Энэхүү хамтын ажиллагаа нь уламжлалт маркетингийн аргаас давж, залуучуудын соёл, нийгмийн нөлөөллөөр дамжуулан хариуцлагатай даатгалын ойлголтыг илүү хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар түгээхийг зорьж байна.

Брэндийн элчийн хувиар BIG GEE нь компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон нийгмийн хариуцлагын (CSR) үйл ажиллагааг бүтээлч, шинэлэг арга барилаар сурталчлан таниулахад дэмжлэг үзүүлж, брэндийн танигдалт, итгэлцэл болон хэрэглэгчийн оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.

Энэхүү хамтын ажиллагаа нь даатгалын салбарын хөгжилд эерэг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ “Иншүрко Даатгал” ХХК-ийн харилцагч төвтэй, тогтвортой өсөлтийн стратегийг хэрэгжүүлэхэд чухал дэмжлэг болох юм.

БИДЭНТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАСНААР

ТУСГАЙ ҮНИЙН САНАЛ

Байгууллагын онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн тусгай үнийн саналаар хамтран ажилладаг.

ДИЖИТАЛ ШИЙДЭЛ

Даатгалын үйлчилгээ болон нөхөн төлбөрийн баримт бүрдүүлэлтийг цахимаар шийдвэрлэдэг.

ЧАДВАРЛАГ БАГ ХАМТ ОЛОН

Даатгалын төдийгүй санхүүгийн салбарын үнэт туршлага, ур чадвартай мэргэжилтнүүдийг багтаан хүний нөөцөө бүрдүүлэн ажиллаж байна.

ТОГТВОРТОЙ ХАРИЛЦАА

Нэг удаагийн гэрээгээр бус, урт хугацааны тогтвортой түншлэлийг эрхэмлэдэг

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулж, байгаль орчинд ээлтэй байх бодлогыг эрхэмлэдэг

ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Даатгуулагчаас шаардлагатай баримт, материалыг хүлээн авсны дараа нөхөн төлбөрийг дунджаар ажлын 3 цагийн дотор шийдвэрлэж байна.

БИД ИТГЭЛ ДААСАН ХАМГААЛАЛТЫГ ҮЗҮҮЛЖ, ХАРИЛЦАГЧИД
БОЛОН ОЛОН НИЙТИЙН ХАМТААР ТОГТВОРТОЙ ИРЭЭДҮЙГ
ЦОГЦЛООН БҮТЭЭХЭД ТУУШТАЙ АЖИЛЛАЖ БАЙНА.



ЭРСДЭЛГҮЙГЭЭР УРАГШИЛЪЯ



ЭРСДЭЛГҮЙГЭЭР УРАГШИЛЪЯ

ЭРСДЭЛГҮЙГЭЭР УРАГШИЛЪЯ



БИД ТАНЫГ ХААНА Ч,
ХЭЗЭЭ Ч ХАМГААЛНА.



